

# ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ

2019 оны 04 дугаар  
сарын 19-ны өдөр

Дугаар А-120

Улаанбаатар  
хот

## Төлөвлөгөө батлах тухай

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсгийг үндэслэн Засгийн газрын 2018 оны 400 дугаар тогтоолоор баталсан “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор ТУШААХ нь:

1. Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийг (2019-2023) хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг бүх шатанд зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Батмөнх/-т даалгасугай.

3. Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөв, олон улсын байгууллагын хөрөнгө оруулалтын арга хэмжээнд тусган, санхүүжилэх арга рэмжээ авч ажиллахыг Бодлого төлөвлөлтийн газар /М.Энх-Амар/, Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Батмөнх/-т тус тус үүрэг болгосугай.

4. Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, шаардлагатай бол хөндлөнгийн үнэлгээг хийлгэх, тайлагнах ажлыг жил бүр зохион байгуулахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Ч.Тавинжил/-т үүрэг болгосугай.

САЙД

Ч. УЛААН

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн А-120 дугаар тушаалын хавсралт

“ЭРЧИМЖСЭН МАЛ АЖ АХУЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ  
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ /2019-2023 он/

д/д	Хөтөлбөрийн зорилт, зорилтот үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа /бүтээгдэхүүн, үр дүн/	Шалгуур үзүүлэлт	Хариуцах байгууллага	Хамтрах байгууллага	Хугацаа /он/
Зорилт 1.”Эрчимжсэн аж ахуйн үйл ажиллагааг төрөлжүүлж, кластер, ложистикийн сүлжээний үйлчилгээг хөгжүүлэх” зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа:						
1	1.1.эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг чиглэл, цар хүрээ, зорилтот зах зээл, бүтээгдэхүүн нийлүүлэлтийн түвшинтэй нь уялдуулан төрөлжүүлэн ангилал, бүсчлэл тогтоох, баталгаажуулах;	Эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлд бүсчлэл тогтоох	тогтоосон бүсчлэлийн тоо	ХХААХҮЯ,	БХБЯ,, Бүх шатны Засаг дарга, ИТХ, Аймаг, нийслэлийн ХХААГ Мэргэжлийн холбоод, сум, дүүргийн ХАА-н тасаг, эрчимжсэн аж ахуй эрхлэгчид	2019-2022
		Эрчимжсэн аж ахуйнуудыг үйл ажиллагааны чиглэлээр төрөлжүүлэн ангилж, баталгаажуулах	төрөлжүүлэн ангилж, баталгаажуулсан аж ахуйн нэгжийн тоо			
		Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх гол бүс нутгийн болон тариалангийн талбайн хил хязгаарыг тогтоох чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах	бүс нутаг тогтоосон аймаг, сум, дүүргийн тоо			
		Эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлээс гарч буй бүтээгдэхүүний эрэлт нийлүүлэлтийн зах зээлийн судалгааг ангилал, бүсчлэлтэй уялдуулан хийх	Судалгааны ажлыг 2-оос доошгүй баталгаажсан бүсчлэлд 6-аас доошгүй төрөлжсөн аж ахуйд хийгдсэн байна.			
2	1.2.сүүний чиглэлийн үхрийн эрчимжсэн аж ахуйг нийслэл орчмын, аймгийн төвийн, тариалангийн бүсийн гэсэн гурван чиглэл, үйл ажиллагааны түвшнээр ангилж, кластер, цогцолборын зохион байгуулалтад оруулах, мэргэжлийн холбоодын үйл ажиллагаанд түшиглэн сүү бэлтгэн нийлүүлэх тогтолцооны шинэчлэлийг дэмжих, хөгжүүлэх;	Сүүний болон хосолмол ашиг шимт үхрийн аж ахуйд кластерын системийн тогтолцоог шинэчлэх, хамтын ажиллагааг бэхжүүлэх	Шинээр бий болгох, шинэчлэх сүүний үхрийн кластерын системийн тоо- 3	ХХААХҮЯ, Мэргэжлийн холбоод	Аймаг, нийслэлийн ХХААГ, хувийн хэвшлийн сүүний болон хосолмол ашиг шимт үхрийн аж ахуй эрхлэгчид	2019-2023
		Сүүний чиглэлийн үхрийн төрөлжсөн аж ахуйг үйл ажиллагааны түвшнээр ангилал замаар цогцолборын зохион байгуулалтад оруулах	Нийслэл орчмын, аймгийн төвийн, тариалангийн бүсэд сүүний чиглэлийн үхрийн төрөлжсөн аж ахуйн нэгжүүд цогцолборын зохион байгуулалтад орсон байна. /сүүний чиглэлийн үхрийн төрөлжсөн аж ахуйн нэгжүүд/			
		Сүүний фермерийн стандартыг тогтоох, эрүүл ахуйн зохистой дадлыг нэвтрүүлэх, зохистой дадлын хэрэгжилтэд хөндлөнгийн баталгаажуулалт, үнэлгээ хийх системийг олон улсын туршлагад үндэслэн нэвтрүүлэх	Сүүний фермерийн стандарт -1, эрүүл ахуйн зохистой дадлыг нэвтрүүлж, зохистой дадлын хэрэгжилтэд хөндлөнгийн баталгаажуулалт, үнэлгээ хийх системийг олон улсын туршлагад үндэслэн нэвтрүүлсэн байна.			

3	1.3.махны чиглэлийн үхэр, хонь үржүүлэх, бордох чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчид, мэргэжлийн холбоод, боловсруулах үйлдвэрийн хамтын ажиллагааг гарал үүслийн баталгаажуулалт, хяналтад суурилсан мал, мах бэлтгэн нийлүүлэх сүлжээнд шилжүүлж, тогтолцооны шинэчлэлийг дэмжих, хөгжүүлэх;	Махны чиглэлийн үхрийн аж ахуйгаас мах бэлтгэн нийлүүлэх кластерын системийн сүлжээг бий болгох, бүртгэх, хамтын ажиллагааг бэхжүүлэх	шинээр бий болгох, шинэчлэх махны үхрийн аж ахуйн кластерын системийн тоо - 3	ХХААХҮЯ, Мэргэжлийн холбоод	Аймаг, нийслэлийн ХХААГ, махны чиглэлийн үхрийн аж ахуй эрхлэгчид	2019-2023
		Хорио цээрийн байгууламж бүхий хонь бордох жишиг аж ахуй байгуулах	Хорио цээрийн байгууламж бүхий хонь бордох жишиг аж ахуйг 3-аас доошгүй байгуулна.			
4	1.4.гахайн аж ахуйн үйлдвэрлэлийг томоохон (500-аас дээш толгой), дунд (150-500 хүртэл толгой), өрхийн (150-аас доош толгой) гэсэн гурван түвшнээр ангилж, цэвэр үүлдрийн үржлийн өсвөр хээлтэгч, хээлтүүлэгчээр хангах үржлийн аж ахуйн үйлчилгээ, тэжээл нийлүүлэлтийн сүлжээ бүхий кластерын зохион байгуулалтыг мэргэжлийн холбооны үйл ажиллагаанд түшиглэн хөгжүүлэхийг бодлогоор дэмжих;	Гахайн аж ахуйд кластерын систем бий болгох	шинээр бий болгох гахайн аж ахуйн кластерын системийн тоо-2	ХХААХҮЯ, Мэргэжлийн холбоод	Аймаг, нийслэлийн ХХААГ, гахайн аж ахуй эрхлэгчид	2019-2023
		Мэргэжлийн холбооны үйл ажиллагаанд суурилан гахайн аж ахуйг үйл ажиллагааны түвшнээр ангилан бүртгэх, баталгаажуулах, кластер системийн үйлчилгээг чиглүүлэх	Үйл ажиллагааны түвшнээр ангилж, баталгаажуулсан аж ахуйн тоо			
5	1.5.зөгийн аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийг бүсчлэл, хамтын ажиллагааны цар хүрээгээр кластерын зохион байгуулалтад оруулахыг бодлогоор дэмжиж, мэргэжлийн холбоодын үйл ажиллагаанд түшиглэн хөгжүүлэх;	Зөгийн аж ахуйд кластерын систем бий болгох	шинээр бий болгох зөгийн аж ахуйн кластерын системийн тоо-2	ХХААХҮЯ, Мэргэжлийн холбоод	Аймаг, нийслэлийн ХХААГ, зөгийн аж ахуй эрхлэгчид	2019-2023
6	1.6.мал аж ахуйн бусад чиглэлийн эрчимжсэн үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг өргөтгөх, сайжруулахад хөнгөлөлттэй зээлийн бодлогоор дэмжих, мэргэжил, арга зүй, технологийн зөвлөгөө өгөх;	Эрчимжсэн аж ахуй эрхлэгчдийг мэргэжил, арга зүй, технологийн зөвлөгөөгөөр хангах системийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах	арга зүй, технологийн зөвлөгөө үзүүлсэн эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийн тоо - 3000 /давхардсан тоогоор/	ХХААХҮЯ, Мэргэжлийн холбоод	Аймаг, нийслэлийн ХХААГ, сум, дүүргийн ХАА-н тасаг, эрчимжсэн МАА эрхлэгчид	2019-2023
		Шувуу, туулай, загасны аж ахуй эрхлэгчдэд зээлийн дэмжлэг үзүүлэх	Шувуу, туулай, загасны аж ахуй эрхлэгч 10-аас доошгүй аж ахуй нэгжид зээлийн дэмжлэг үзүүлэх			
7	1.7.цэвэр үүлдрийн үржлийн мал, зориулалтын техник, тоног төхөөрөмж, тэжээл нийлүүлэх, бүтээгдэхүүнийг үйлдвэрт хүргэх зэрэг ложистикийн төрөлжсөн үйлчилгээг хөгжүүлэхэд хөнгөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэх;	Цэвэр үүлдрийн үржлийн малыг зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэх ложистикийн төрөлжсөн үйлчилгээг хөгжүүлэх	ложистикийн үйлчилгээ үзүүлэгчийн тоо- 50	ХХААХҮЯ, ЗТЯ	Бүх шатны Засаг дарга, боловсруулах үйлдвэр, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид	2019-2023

		Эрчимжсэн аж ахуйд шаардагдах техник, тоног төхөөрөмжийг захиалах, нийлүүлэх, хүргэх ложистикийн төрөлжсөн үйлчилгээг хөгжүүлэх	ложистикийн үйлчилгээ үзүүлэгчийн тоо- 30	ХХААХҮЯ, ЗТЯ	Бүх шатны Засаг дарга, боловсруулах үйлдвэр, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид	2019-2023
		Төрөл бүрийн малын тэжээл, өвс бэлтгэх, захиалгаар хүргэх ложистикийн төрөлжсөн үйлчилгээг хөгжүүлэх	ложистикийн үйлчилгээ үзүүлэгчийн тоо -100	ХХААХҮЯ, ЗТЯ	Бүх шатны Засаг дарга, боловсруулах үйлдвэр, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид	2019-2023
		Эрчимжсэн МАА-н үйлдвэрлэлд орчин үеийн дэвшилтэд технологийн тоног төхөөрөмж, техник хэрэгслийг нэвтрүүлэхэд зээлийн дэмжлэг үзүүлэх.	зээлийн дэмжлэг 10-аас доошгүй аж ахуй нэгжид үзүүлсэн байна.	ХХААХҮЯ, Мэргэжлийн холбоод		
		Эрчимжсэн аж ахуй эрхлэгчдээс үйлдвэрлэсэн түүхий эд, бүтээгдэхүүнийг зориулалтын тэвэрээр захиалгат газар, үйлдвэрт хүргэх ложистикийн төрөлжсөн үйлчилгээг хөгжүүлэх	ложистикийн үйлчилгээ үзүүлэгчийн тоо -100	ХХААХҮЯ, ЗТЯ	Бүх шатны Засаг дарга, боловсруулах үйлдвэр, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид	2019-2023
8	1.8.эрчимжсэн аж ахуйд сүрэг сэлбэх үржлийн гойд ашиг шимт хээлтэгч, эх сүргийг нийлүүлэх чиглэлээр дагнасан үржлийн аж ахуй эрхлэгчид олон улсын байгууллагатай хамтарсан төсөл хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;	Эрчимжсэн аж ахуйд чиглэл тус бүрт сүрэг сэлбэх үржлийн гойд ашиг шимт мал нийлүүлэх үржлийн аж ахуйнуудыг бий болгох	шинээр бий болсон үржлийн аж ахуйн тоо -25	ХХААХҮЯ	Бүх шатны Засаг дарга, ОУБ	2019-2023
9	1.9.эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчид бэлчээр, хадлангийн газар, таримал тэжээл тариалах тариалангийн талбайг гэрээгээр ашиглуулах эрх зүйн орчинг бүрдүүлэх, хэрэгжилтийг хангах.	Хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх	Хууль, тогтоомж, шийдвэрийн тоо-1	ХХААХҮЯ	БХБЯ, ОУБ, ЭМАА эрхлэгчид	2019-2020
		Бэлчээр дэх өвс, ургамлын бүтэц, тархац, ургац, ус, тэжээлийн нөөцийн урьдчилсан судалгааг хийж, эрчимжсэн мал аж ахуй, түүнд суурилсан үйлдвэрлэлийг бүсчилсэн, эсхүл хэсэгчилсэн хэлбэрээр хөгжүүлэх чиглэл, бүсийг тогтоох	Судалгааны тоо – 5 бүсээр	ХХААХҮЯ	БХБЯ, ОУБ, ЭМАА эрхлэгчид	2019-2020

Зорилт 2."Мал, амьтны гаралтай зарим нэр төрлийн бүтээгдэхүүний импортыг бууруулах, экспортыг дэмжих, дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах" зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа:рилт 3.1.Эрчимжсэн аж ахуйн үйл ажиллагааг төрөлжүүлж, клий

1	2.1.шингэн сүү, сүүн бүтээгдэхүүн, үхрийн хөлдүү мах, өндөг, гахай,шувууны мах, өөх, зөгийн балны импортыг үе шатайгаар бууруулах, зарим нэр төрлийн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх арга хэмжээг мэргэжлийн холбоодтой хамтран төлөвлөж, хэрэгжүүлэх;	Шингэн сүү, сүүн бүтээгдэхүүнийг импортыг бууруулах төлөвлөгөөг баталж хэрэгжүүлэх	мэргэжлийн холбоотой хамтран батлаж хэрэгжүүлэх төлөвлөгөөний тоо-1	ХХААХҮЯ, мэргэжлийн холбоо	Сүүний болон хосолмол ашиг шимт үхрийн аж ахуй эрхлэгчид	2019-2023
		Эрчимжсэн үхрийн аж ахуйн махны экспортыг нэмэгдүүлэх, үхрийн хөлдүү махны импортыг бууруулах төлөвлөгөөг баталж хэрэгжүүлэх	мэргэжлийн холбоотой хамтран батлаж хэрэгжүүлэх төлөвлөгөөний тоо-1	ХХААХҮЯ, Махны үхэр үржүүлэгчдийн холбоо	Махны холбоо, махны чиглэлийн үхрийн аж ахуй эрхлэгчид	2019-2023
		Шувууны мах, өндөгний импортыг бууруулах төлөвлөгөөг баталж хэрэгжүүлэх	мэргэжлийн холбоотой хамтран батлаж хэрэгжүүлэх төлөвлөгөөний тоо-1	ХХААХҮЯ, Шувуу үржүүлэгчдийн холбоо	Шувууны аж ахуй эрхлэгчид	2019-2023
		Гахайн мах, өөхний импортыг бууруулах төлөвлөгөөг баталж хэрэгжүүлэх	мэргэжлийн холбоотой хамтран батлаж хэрэгжүүлэх төлөвлөгөөний тоо-1	ХХААХҮЯ, Гахай үржүүлэгчдийн холбоо	Гахайн аж ахуй эрхлэгчид	2019-2023
		Зөгийн балны импортыг бууруулах, экспортыг нэмэгдүүлэх төлөвлөгөөг баталж хэрэгжүүлэх	мэргэжлийн холбоотой хамтран батлаж хэрэгжүүлэх төлөвлөгөөний тоо-1	ХХААХҮЯ, Зөгий үржүүлэгчдийн холбоо	Зөгийн аж ахуй эрхлэгчид	2019-2023
		Эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлийн хөгжлийн чиг хандлагын судалгааг хийх	Судалгааны тоо-1	ХХААХҮЯ	Мэргэжлийн холбоод, судлаачид	2019-2020
		Мал, амьтны гаралтай зарим нэр төрлийн эм, гоо сайхны бүтээгдэхүүний түүхий эдийг бэлтгэх, үйлдвэрлэх, экспортлох чиглэлийн судалгааг явуулах, эрдэм шинжилгээний болон үйл ажиллагааны тухайлсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх	Судалгааны тоо-1 Эрдэм шинжилгээний төслийн тоо- 2	ХХААХҮЯ	Мэргэжлийн холбоод, судлаачид	2020-2023
2	2.2.сүүний чиглэлийн үхрийн эрчимжсэн аж ахуйн үйлдвэрлэл, технологийн түвшинг сайжруулан, гойд ашиг шимт үхрийн тоог нэмэгдүүлэх, зохиомол хээлтүүлгийн цар хүрээг тэлэх арга хэмжээг	Сүүний эрчимжсэн одоо ажиллаж байгаа аж ахуйнуудыг холдинг компанид нэгдэн хөгжихийг дэмжих замаар дотоодын сүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх	Шингэн сүү үйлдвэрлэлийн өсөлт- 40 хувь	ХХААХҮЯ, Монголын сүүний нэгдсэн холбоо эрхлэгчид	Монголын сүүний нэгдсэн холбоо, сүүний эрчимжсэн аж ахуй эрхлэгчид боловсруулах үйлдвэр,	2019-2023

	хэрэгжүүлж, дотоодын шингэн сүүний үйлдвэрлэл, боловсруулалтыг өсгөх, импортын шингэн болон шар сүүг 100 хувиар халж, цөцгийн тос, аарц тараг зэрэг сүүн бүтээгдэхүүний импортыг 30 хүртэл хувиар бууруулах;	Хуурай сүүний импортын татварыг боломжит дээд хэмжээнд нэмэгдүүлж тогтоох	нэмэлт, өөрчлөлт оруулах хууль тогтоомжийн тоо – 1	ХХААХҮЯ	СЯ, Монголын сүүний нэгдсэн холбоо	2021-2022
		Шингэн сүү, сүүн бүтээгдэхүүний импортын хэмжээг бууруулах	импортын шингэн сүүний хэмжээ– 0 хувь импортын шар сүүний хэмжээ -0 хувь	Сүүний үхрийн аж ахуй эрхлэгчид	Боловсруулах үйлдвэр, мэргэжлийн холбоод	2019-2023
		Сүү, сүүн бүтээгдэхүүний импортыг бууруулах	импортын хуурай сүүг бууруулах хэмжээ -30,0 хувь импортын бусад сүүн бүтээгдэхүүнийг бууруулах хэмжээ-15 хувь	Сүүний үхрийн аж ахуй эрхлэгчид	Боловсруулах үйлдвэр, мэргэжлийн холбоод	2019-2023
3	2.3.махны чиглэлийн үхэр, хонины аж ахуйн технологийн эрчимжүүлэлтийг дэмжиж, махны экспортын бодлогод нийцүүлэн мал бордох үр ашигтай аргачлал, технологийг нэвтрүүлж мах үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх, үхрийн хөлдүү махны импортыг бүрэн халж, махны экспортыг 30,0 хувиар нэмэгдүүлэх;	Махны чиглэлийн үхэр, хонины аж ахуйн эрчимжүүлэлтийг дэмжих	махны үхэр, хонины эрчимжсэн аж ахуйн тооны өсөлт- 20 хувь	Махны үхрийн аж ахуй эрхлэгчид	Боловсруулах үйлдвэр, мэргэжлийн холбоод	2019-2023
		Мал бордох үр ашигтай аргачлал, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх	үйлдвэрлэлд нэвтрүүлсэн дэвшилтэт технологи, аргачлалын тоо - 5	Махны үхрийн аж ахуй эрхлэгчид	Боловсруулах үйлдвэр, мэргэжлийн холбоод	2019-2023
		Үхрийн хөлдүү махны импортыг бууруулж, экспортыг нэмэгдүүлэх	импортын үхрийн хөлдүү махны хэмжээ– 0 хувь  үхрийн махны экспортын өсөлт - 30,0 хувь	Махны үхрийн аж ахуй эрхлэгчид	Боловсруулах үйлдвэр, мэргэжлийн холбоод	2019-2023
4	2.4.шувууны аж ахуйн технологийн түвшин, эрчимжүүлэлтийг сайжруулах, сүрэг сэлбэх хэрэгцээнд дэгдээхэй нийлүүлэх үржлийн аж ахуйд бодлогын дэмжлэг үзүүлэх, мэргэжлийн холбоодын үйл ажиллагаанд түшиглэн шувууны мах, өндөг үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, импортын өндгийг 90 хувь, шувууны махыг 30 хувиар бууруулах;	Шувууны аж ахуйн технологийн түвшин, эрчимжүүлэлтийг дэмжиж, шувууны мах, өндөг үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх	-шувууны мах үйлдвэрлэлийн өсөлт 30 хувь өндөг үйлдвэрлэлийн өсөлт- 50 хувь	Шувууны аж ахуй эрхлэгчид	Мэргэжлийн холбоод	2019-2023
		Шувууны үржлийн аж ахуйд бодлогын дэмжлэг үзүүлэх	дэмжлэг үзүүлсэн үржлийн аж ахуйн тоо -5	ХХААХҮЯ	Шувууны аж ахуй эрхлэгчид	2020-2021
		Өндөг, шувууны махны импортын хэмжээг бууруулах	-импортын өндөгний бууралт -90,0 хувь –импортын шувууны махны бууралт - 30 хувь	Шувууны аж ахуй эрхлэгчид	Мэргэжлийн холбоод	2019-2023

5	2.5.том, дунд түвшний гахайн аж ахуйг чадавхижуулж дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах, үржлийн өсвөр гахай, бүрэн найрлагат гэжээлээр хангах кластерын тогтолцоог хөгжүүлэн, гахайн мах, өөхний импортыг 15,0 хувиар бууруулах;	Гахайн аж ахуйг чадавхижуулж, дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх	гахайн том, дунд түвшний аж ахуйн тооны өсөлт- 20 хувь	Гахайн эрчимжсэн аж ахуй эрхлэгчид	Боловсруулах үйлдвэр, мэргэжлийн холбоод	2019-2023
		Гахайн мах, өөхний импортын хэмжээг бууруулах	импортын гахайн мах, өөхний бууралт -15 хувь	Гахайн эрчимжсэн аж ахуй эрхлэгчид	Боловсруулах үйлдвэр, мэргэжлийн холбоод	2019-2023
6	2.6.зөгийн аж ахуйн зохион байгуулалт, үйлдвэрлэлийн технологийн түвшин, зөгийчдийн мэдлэг, ур чадварыг сайжруулан дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах ажлыг мэргэжлийн холбоотой хамтран гүйцэтгэж, зорилтот зах зээлд бэлтгэн нийлүүлэх зөгийн бал, бусад дагалдах бүтээгдэхүүний тоо хэмжээ, нэр төрлийг нэмэгдүүлэн, импортын зөгийн балыг 70 хувиар бууруулах;	Зөгийн аж ахуйн зохион байгуулалтыг сайжруулах	зохион байгуулалтад оруулах зөгийн кластерын систем -1	Зөгийн аж ахуй эрхлэгчид	Мэргэжлийн холбоод	2019-2023
		Зах зээлд бэлтгэн нийлүүлэх зөгийн бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх	- зөгийн бал үйлдвэрлэлийн өсөлт- 30 хувь, - зөгийн бусад дагалдах бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээний өсөлт – 5 хувь	Зөгийн аж ахуй эрхлэгчид	Мэргэжлийн холбоод	2019-2023
		Зөгийчдийн мэдлэг, ур чадварыг сайжруулах	технологийн мэдлэг олгох сургалтын тоо - жил бүр 2 удаа	Зөгийн аж ахуй эрхлэгчид	Мэргэжлийн холбоод	2019-2023
		Зөгийн балны импортыг бууруулж, экспортыг нэмэгдүүлэх	-импортын зөгийн балны бууралт-70,0 хувь -зөгийн балны экспортын өсөлт 10,0 хувь	Зөгийн аж ахуй эрхлэгчид	Мэргэжлийн холбоод, ОУБ	2019-2023
7	2.7.мал,амьтны гаралтай импортын ижил төстэй бараа, бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах тарифын болон тарифын бус зохицуулалтыг тухай бүр авч хэрэгжүүлэх;	Эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн зарим үйл ажиллагааг ААНОАТ-аас чөлөөлөх эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх	нэмэлт, өөрчлөлт оруулсан хууль, тогтоомжийн тоо -2	ХХААХҮЯ	СЯ, Мэргэжлийн холбоод	2021-2022
8	2.8.шувууны аж ахуйд сүрэг сэлбэх үр тогтсон өндөг, үржлийн амьд шувуу, дэгдээхэйг импортоор оруулахад татварын хөнгөлөлт үзүүлэх, импортын өндгөнд 5 дугаар сарын 01-нээс 11 дүгээр сарын 15-ны хооронд улирлын хязгаарлалт тогтоох асуудлыг судалж, хэлэлцүүлэх.	Импортын барааны татварын хувь хэмжээг тогтоох асуудлыг судалж, холбогдох эрх зүйг бүрдүүлэх	судалж, хэлэцүүлсэн арга хэмжээ, төслийн тоо -2	ХХААХҮЯ	СЯ, ГХЯ, МҮХАҮТ, Мэргэжлийн холбоо	2020-2021

Зорилт 3."Гойд ашиг шимт үржлийн мал, амьтны тоог нэмэгдүүлж, хот суурингийн хүн амын хүнсний хэрэгцээний сүү, мах, өндөг, зөгийн бал болон бусад түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хангамжийг сайжруулах" зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа:рилт

1.	3.1.сүүний чиглэлийн цэвэр үүлдрийн 3600 хээлтэй гунж, хосолмол ашиг шимт 2200 хээлтэй гунжийг импортлон нутагшуулах, тэдгээрийн үр төлд удам зүйн үнэлгээ хийх, бүртгэлжүүлэх арга хэмжээг мэргэжлийн байгуулага, холбоодын хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлж, сүүний үхрийн аж ахуйн эрчимжүүлэлт, кластерыг хөгжүүлэх	Сүүний чиглэлийн цэвэр үүлдрийн үхэр импортлож, нутагшуулах	импортлон нутагшуулсан цэвэр үүлдрийн үхрийн тоо: -сүүний чиглэлийн хээлтэй гунж- 3600 -хосолмол ашиг шимийн хээлтэй гунж - 2200	ХХААХҮЯ, Сүүний үхрийн аж ахуй эрхлэгчид	СЯ, Засгийн газрын тусгай сан, Монголын сүүний нэгдсэн холбоо, ОУБ	2020-2023
		Сүүний чиглэлийн эрчимжсэн аж ахуй, тэдгээрт үржүүлж байгаа үхэр сүргийг бүртгэлийн нэгдсэн тогтолцоонд хамруулах	Малын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлсэн сүүний үхрийн аж ахуй эрхлэгчдийн хувь-100 - сүүний үхрийн тоо - 70,0 мянга	ХХААХҮЯ, Сүүний үхрийн аж ахуй эрхлэгчид	Монголын сүүний нэгдсэн холбоо, ОУБ	2020-2023
		Сүүний чиглэлийн цэвэр үүлдрийн үхрийн үр төлд удам зүйн үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах	удам зүйн үнэлгээ хийсэн үхрийн тоо - 2100	ХХААХҮЯ, Сүүний үхрийн аж ахуй эрхлэгчид	Монголын сүүний нэгдсэн холбоо, ОУБ	2020-2023
		Европын бүсээс цэвэр үүлдрийн сүүний болон хосолмол ашиг шимт үржлийн хээлтэй гунж, гүн хөлдөөсөн үр экспортлох, импортлох хорио цээрийн нөхцөл тохирох	Тохирсон хорио цээрийн нөхцөл	МЭЕГ, МХЕГ	ХХААХҮЯ, Сүүний үхрийн аж ахуй эрхлэгчид	2019-2021
2	3.2.махны чиглэлийн үхэр, хонины аж ахуйд махны хэмжээ, гарцыг нэмэгдүүлэх үржил селекцийн ажлыг явуулж, гадаадаас авчирсан махны чиглэлийн гойд ашиг шимт үхэр, хонины тэжээллэг, арчилгаа, маллагааны технологийг мөрдүүлж, удам зүйн үнэлгээгээр шалгарсан үржлийн өсвөр бухыг бойжуулах, зохиомол хээлтүүлгийн үйлчилгээний хамрах хүрээг тэлэх, бүсчлэлийн бодлогоор махны чиглэлийн үхэр, хонины аж ахуйн эрчимжүүлэлт, кластерыг дэмжин хөгжүүлэх;	Үхэр, хонины махны гарцыг нэмэгдүүлэх үржил селекцийн ажлын хөтөлбөрийг баталж, хэрэгжүүлэх	батлуулж, хэрэгжүүлэх хөтөлбөрийн тоо -2	ХХААХҮЯ, Сүүний үхрийн аж ахуй эрхлэгчид	Монголын сүүний нэгдсэн холбоо, ОУБ	2020-2023
		Удам зүйн үнэлгээгээр шалгарсан махны чиглэлийн үржлийн өсвөр бух, хуцыг бойжуулах, зохиомол хээлтүүлгийн үйлчилгээ дэмжих	дэмжлэг үзүүлсэн иргэн, аж ахуйн нэгжийн тоо -100	ХХААХҮЯ, Засгийн газрын тусгай сан	МУСҮТ, Махны үхрийн, хонины аж ахуй эрхлэгчид мэргэжлийн холбоо, ОУБ	2019-2023
		Махны чиглэлийн үхэр, хонины аж ахуйн хамрах хүрээг бүсчлэлийн бодлогоор тэлж, эрчимжүүлэлт, кластерыг хөгжүүлэх	махны чиглэлийн үхэр, хонины аж ахуйг хөгжүүлэх бүсчлэлийн бодлогын баримт бичиг -1, аж ахуй эрхлэгчдийн тооны өсөлт 20 хувь	ХХААХҮЯ, Засгийн газрын тусгай сан	МУСҮТ, Махны үхрийн аж ахуй эрхлэгчид Мэргэжлийн холбоо, ОУБ	2019-2023



3	3.3.өндөгний болон махны чиглэлийн тухайлсан үүлдрийн үржлийн 20,0 мянган өндгийг импортлох, хоногийн настай дэгдээхэйг бойжуулж аж ахуйн нэгжүүдийн сүрэг сэлбэх хэрэгцээнд нийлүүлэх үржлийн аж ахуйг бий болгох, өндөгний чанар, баталгаажуулалт, импортын өндөгний хяналтыг сайжруулах чиглэлээр мэргэжлийн байгууллага, холбоод хамтын ажиллагааг нягтруулж, үржлийн аж ахуй, мал эмнэлгийн үйлчилгээ, тэжээл бэлтгэн нийлүүлэх сүлжээ бүхий шувууны аж ахуйн эрчимжүүлэлт, кластерыг дэмжин хөгжүүлэх;	Бодлогын түвшинд цэвэр үүлдрийн тахианы үржлийн өндөг импортлохыг дэмжих	импортлох үржлийн өндөгний тоо - 20,0 мянга	Шувууны аж ахуй эрхлэгчид	ХХААХҮЯ, Шувуу үржүүлэгчдийн холбоо	2019-2023
		Хоногийн настай дэгдээхэй бойжуулах, нийлүүлэх үржлийн аж ахуйг бий болгох	шувууны үржлийн аж ахуйн тоо -5	Шувууны аж ахуй эрхлэгчид	Шувуу үржүүлэгчдийн холбоо	2019-2023
		Дотоодын болон импортын өндөгний чанарын баталгаажуулалт, хяналтыг сайжруулах	баталгаажуулалт, хяналт хийх үзлэгийн тоо - сар тутамд	МХЕГ, мэргэжлийн холбоод	Шувууны аж ахуй эрхлэгчид	2019-2023
		Шувууны аж ахуйд мал эмнэлгийн үйлчилгээг сайжруулах	мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх нэгжийн тоо - 20	МЭЕГ	Мал эмнэлгийн нэгж, Шувууны аж ахуй эрхлэгчид	2019-2023
		Шувуунд зориулсан тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, импортын шувууны тэжээлийг бууруулах	-тэжээл үйлдвэрлэлийн өсөлт- 20 хувь -шувууны тэжээлийн импортын хэмжээний бууралт – 20 хувь	Тэжээлийн үйлдвэр	Шувууны аж ахуй эрхлэгчид	2019-2023
4	3.4.цэвэр үүлдрийн 1000 мэгж, 50 бодонг Европын Европын бүсээс импортлон гахайн аж ахуйд үржлийн шинэ хөтөлбөр хэрэгжүүлэн өсвөр хээлтэгч, хээлтүүлэгч бойжуулж аж ахуйн нэгжүүдийн сүрэг сэлбэх хэрэгцээг хангах, зохиомол хээлтүүлгийн явуулын үйлчилгээ үзүүлэх, бүртгэлжүүлэх арга хэмжээг мэргэжлийн байгууллага, холбоод хамтран хэрэгжүүлэхийг дэмжиж, үржлийн аж ахуй, мал эмнэлгийн үйлчилгээ, тэжээл бэлтгэн нийлүүлэх сүлжээ бүхий гахайн аж ахуйн эрчимжүүлэлт, кластерыг дэмжин хөгжүүлэх;	Бодлогын түвшинд Европын бүсээс цэвэр үүлдрийн үржлийн гахай импортлоход дэмжлэг үзүүлэх	импортлох цэвэр үүлдрийн гахайн тоо: - 1000 мэгж, - 50 бодон	ХХААХҮЯ, Гахайн аж ахуй эрхлэгчид	Мэргэжлийн холбоо, ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САН, ОУБ	2019-2023
		Гахайн аж ахуйд үржил селекцийн ажлын шинэ хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх	боловсруулж, хэрэгжүүлэх хөтөлбөрийн тоо -1	ХХААХҮЯ, Мэргэжлийн холбоо	Гахайн аж ахуй эрхлэгчид	2019-2023
		Гахайн аж ахуйд зохиомол хээлтүүлгийн явуулын үйлчилгээг нэвтрүүлэх	үйлчилгээ үзүүлэх гахайн тоо- 5000	Мэргэжлийн холбоо,	Гахайн аж ахуй эрхлэгчид, Мал үржүүлгийн техникчид	2020-2023
		Гахайн аж ахуйн эрчимжүүлэлт, кластерыг дэмжин хөгжүүлэх	дэмжлэг үзүүлсэн гахайн аж ахуйн тоо- 20	ХХААХҮЯ, Мэргэжлийн холбоо,	Гахайн аж ахуй эрхлэгчид	2020-2023
5	3.5.өндөр ашиг шимт, баталгаажсан зөгийн үүлдрийн 2000 бүлийг импортлон нутагшуулах, дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний	Өндөр ашиг шимт, баталгаажсан зөгийн үүлдрийн 2000 бүлийг импортлон нутагшуулахад дэмжлэг үзүүлэх	импортлох баталгаажсан зөгийн үүлдрийн тоо: - 2000 бүл	ХХААХҮЯ, Зөгийн аж ахуй эрхлэгчид	Мэргэжлийн холбоо, Засгийн газрын тусгай сан, ОУБ	2020-2021

	чанарыг баталгаажуулах, зөгийн үржлийн ажлыг сайжруулах, чадавхижуулах арга хэмжээг мэргэжлийн байгууллага, холбоодтой хамтран хэрэгжүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтын дэмжлэгээр зөгийн аж ахуйн кластерыг хөгжүүлэх;	Зөгийн дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний чанарыг баталгаажуулах, хяналт тавих системийг хөгжүүлэх	баталгаажуулалт, хяналт хийх үзлэгийн тоо – жилд 2-оос доошгүй удаа	МХЕГ, мэргэжлийн холбоод	Зөгийн аж ахуй эрхлэгчид	2019-2023
		Зөгийн аж ахуйг чадавхижуулах, кластерын систем хөгжүүлэх арга хэмжээг гадаадын хөрөнгө оруулалтын дэмжлэгээр хэрэгжүүлэх	Зөгийн бүлийн тооны өсөлт 3,0 хувь Зөгийн бал үйлдвэрлэлийн өсөлт- 3,0 дахин	Зөгийн аж ахуй эрхлэгчид	Мэргэжлийн холбоо, ХХААХҮЯ, ОУБ	2020-2023
6	3.6. хот, суурингийн хүн амын хүнсний хэрэгцээнд эрчимжсэн аж ахуйгаас бэлтгэн нийлүүлэх сүү, мах, өндөг, зөгийн бал болон бусад түүхий эд, бүтээгдэхүүний хангамж, хүртээмж, аюулгүй байдлын баталгааг сайжруулах үйл ажиллагаанд бодлогын болон санхүүжилтийн дэмжлэг үзүүлэх.	Эрчимжсэн аж ахуйнуудаас бэлтгэн нийлүүлэх түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг баталгаажуулах тогтолцоог бүрдүүлэх	Бүртгэлийн нэгдсэн системд хамруулсан иргэн, аж ахуйн нэгжийн тоо -1000	ХХААХҮЯ,	МЭЕГ, Мэргэжлийн холбоо, ОУБ	2019-2023
		Цэцэрлэг, бага ангийн хоол, үдийн цайнд үнээний эрүүл, цэвэр сүү боловсруулж үйлдвэрлэсэн сүү, тараг өдөр бүр уулгах дэд хөтөлбөр хэрэгжүүлэх	Цэцэрлэг, сургууль дээр сүү, тараг тогтмол уух хүүхдийн тооны өсөлт 60 хувь	ХХААХҮЯ	Монголын сүүний нэгдсэн холбоо	2019-2023
		Шингэн сүүний чанар, аюулгүй байдал, гарал үүслийг баталгаажуулах бүртгэлийн системийг хөгжүүлэх	Үйлдвэрт нийлүүлсэн шингэн сүүнд баталгаа өгөх хамралтын хувь - 100 хувь	ХХААХҮЯ	Монголын сүүний нэгдсэн холбоо, ЭМАА-н үйлдвэрлэл эрхлэгчид,	2020-2023
		Эрчимжсэн аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэлт, чанар, аюулгүй байдлыг сайжруулахад санхүүжилтийн дэмжлэг үзүүлнэ	Чанар, аюулгүй байдлын баталгаажуулалтыг тогтмолжуулсан эрчимжсэн аж ахуй эрхлэгчдийн тоо - 500	ХХААХҮЯ	Монголын сүүний нэгдсэн холбоо, ЭМАА-н үйлдвэрлэл эрхлэгчид, ОУБ	2020-2023
7	3.7. эрчимжсэн аж ахуй, тариалангийн үйлдвэрлэлийг хослон эрхлэх үйл ажиллагааг бодлогоор дэмжиж, гурилын үйлдвэрүүдийг түшиглэн бүс нутгийн хэмжээний тэжээл үйлдвэрлэл, тэжээл хүргэлтийн үйлчилгээний ложистикийг хөгжүүлэх.	Эрчимжсэн аж ахуй, тариалангийн үйлдвэрлэл хослон эрхлэх үйл ажиллагааг бодлогоор дэмжих	хосолсон аж ахуй эрхлэгчдийн тооны өсөлт -20 хувь	ХХААХҮЯ	Бүх шатны Засаг дарга, ЭМАА-н үйлдвэрлэл эрхлэгчид	2019-2023
		Аймаг, бүсийн гурилын болон тэжээлийн үйлдвэрүүдийн хүчин чадал ашиглалтыг нэмэгдүүлэх	Хүчин чадлын ашиглалтын өсөлт – 20 хувь	Тэжээлийн үйлдвэрүүд	Бүх шатны Засаг дарга, ЭМАА-н үйлдвэрлэл эрхлэгчид	2019-2023

8	3.8.одоо байгаа малын тэжээлийн үйлдвэр, цехийн тоо, байршил, хүчин чадлын ашиглалтын түвшинг тогтоож, тэжээлийн үндсэн түүхий эдийн нөөцийг бүрдүүлэхэд хөнгөлттэй зээлийн дэмжлэг үзүүлж, эрчимжсэн аж ахуйн хүчит тэжээлийн хангамжийг 30 хувиар сайжруулах.	Малын тэжээлийн үйлдвэр, цехийн тоо, байршил, хүчин чадлын ашиглалтын түвшинг тогтоох	Судалгааны ажлын тайлан -1	ХХААХҮЯ	Тэжээлийн үйлдвэрүүд	2019
		Эрчимжсэн аж ахуйн тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, хүргэлтийн үйлчилгээг сайжруулах	эрчимжсэн мал аж ахуйн тэжээлийн хангамжийн өсөлт 40,0 хувь	ЭМАА-н үйлдвэрлэл эрхлэгчид,	Тэжээлийн үйлдвэрүүд, Мэргэжлийн холбоод	2019-2023
9	3.9.тариалангийн 100,0 мянга хүртэлх га талбайд тэжээлийн ургамал тариалж, эрчимжсэн аж ахуйн шүүст болон ногоон тэжээлийн хангамжийг 50 хувиар нэмэгдүүлэх.	Малын тэжээлийн ургамал тариалах тариалангийн талбайг эргэлтэнд оруулах	тэжээлийн ургамал тариалах талбайн хэмжээ- 100,0 мянга хүртэлх га	ЭМАА-н үйлдвэрлэл эрхлэгчид	Тэжээлийн үйлдвэрүүд, Мэргэжлийн холбоод	2019-2023
		Эрчимжсэн аж ахуйн шүүст болон ногоон тэжээлийн хангамжийг нэмэгдүүлэх	шүүст болон ногоон тэжээл хангамжийн өсөлт- 50 хувь	ЭМАА-н үйлдвэрлэл эрхлэгчид,	Тэжээлийн үйлдвэрүүд, Мэргэжлийн холбоод	2019-2023
		Малын тэжээлийн үр, таримал болон хүчит тэжээлийг татвар, НӨАТ-аас чөлөөлөх эрх зүйн орчинг судлах, холбогдох төслийг боловсруулж хэлэлцүүлэх	Боловсруулж, хэлэлцүүлсэн эрх зүйн актын төслийн тоо - 1	ХХААХҮЯ	СЯ, Мэргэжлийн холбоод	2019-2023
		Улсын нөөцөд малын ногоон тэжээл, шүүст тэжээл нөөцлөдөг тогтолцоог бий болох	Улсын нөөцөд бүрдүүлэх ногоон, шүүст тэжээлийн эзлэх хувийн жин – 10 хувь	ЭМАА-н үйлдвэрлэл эрхлэгчид	Тэжээлийн үйлдвэрүүд, Мэргэжлийн холбоод	2020-2023
		Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд зориулагдсан өвс, тэжээл хадгалах, борлуулах тусгай цэг бий болгох	30000-с дээш хүн амтай суурин газарт бий болсон цэгийн тоо – 5, үүний дотор Улаанбаатарт бий болгосон цэгийн тоо - 2	Тэжээлийн үйлдвэрүүд,	Мэргэжлийн холбоод	2020-2023
10	3.10.гахай, шувууны тэжээлийн орцын үндсэн болон бусад түүхий эд, шар буурцаг, наранцэцэгийн шахдас, төмрийн бэлдмэл, амин дэм, амин хүчлийн импортын татварыг бууруулах асуудлыг судалж, шийдвэрлүүлэх.	Импортын барааны татварын хувь хэмжээг шинэчлэх, өөрчлөх асуудлыг судалж, холбогдох эрх зүйн баримт бичгийг боловсруулан хэлэлцүүлэх	судалж, хэлэлцүүлсэн арга хэмжээ, төслийн тоо -1	ХХААХҮЯ м,	СЯ, ГХЯ, МҮХАҮТанхим, Мэргэжлийн холбоо	2020-2021

Зорилт 4.” Эрчимжсэн аж ахуйд байгаль орчинд ээлтэй техник, технологийн шинэчлэл, сайжруулалтыг үе шаттай хэрэгжүүлж, бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлэх” зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа:рилт

1	4.1.бүс нутгийн хөгжлийн бодлогод нийцүүлэн хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, технологийн паркийн системд эрчимжсэн мал аж ахуйн кластерыг хөгжүүлэхэд бодлогын дэмжлэг үзүүлэх;	Бүсчилсэн хөгжлийн бодлогод нийцүүлж, эрчимжсэн мал аж ахуйн кластерыг хөгжүүлэх	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, технологийн паркийн системд холбогдсон эрчимжсэн аж ахуйн тоо -5	ХХААХҮЯ, ҮХГ	СЯ, бүх шатны Засаг дарга, Мэргэжлийн холбоод, ЭМАА-н үйлдвэрлэл эрхлэгчид	2020-2023
		ЭМАА-н үйлдвэрлэл эрхлэгчдэд санхүү, хүний нөөц, маркетинг, хууль зүй болон бусад чиглэлээр сургалт хийж, технологийн зөвлөгөө үзүүлэх	Сургалтад хамрагсдын тоо – жилд 200-иас доошгүй Технологийн зөвлөгөө - жилд 500	ХХААХҮЯ, Аймаг, нийслэлийн ХХААГ	ХААИС-ийн МААБТС, сум, дүүргийн ХАА-тасаг, мэргэжлийн холбоод	2020-2021
		Шингэн сүү үйлдвэрлэх нэмүү өртгийн хэлхээний дэмжих үйл ажиллагааны хүрээнд хөдөө аж ахуйн зохистой дадлын болон технологийн сургалтыг тогтмол зохион байгуулах, зөвлөгөө өгөх үйлчилгээг нэвтрүүлэх, хэрэгжилтэд мониторинг хийх	Сургалтад хамрагсдын тоо – жилд 100-иас доошгүй Мониторингийн тоо -1 удаа	ХХААХҮЯ, Аймаг, нийслэлийн ХХААГ	ХААИС-ийн МААБТС, сум, дүүргийн ХАА-тасаг, мэргэжлийн холбоод	2020-2021
